

II. ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ ТӨРИЙН МЕХАНИЗМ

A. Үндсэн зорилго

7. Монгол Улс хүний эрхэмсэг оршихуй, үнэт зүйлсийг хүндэтгэн үздэг. Ийм ч учраас хүн бүр ямар нэгэн алагчлалгүйгээр өөрийн салшгүй эрх, эрх чөлөөгөө эдлэх тэр боломжийг нь бүрдүүлж өгөх үндсэн үүргээ гүнээ ухамсарладаг бөгөөд хүний эрх, эрх чөлөөг дээдлэх нь угаасаа Монгол төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болно.

8. Иргэний болон улс төрийн эрхийн хүрээнд хүний амьд явах, халдашгүй байх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх, эвлэлдэн нэгдэх, тайван жагсаал, цуглаан хийх, түүнд оролцох, чөлөөтэй зорчих, хувийн нууцтай байх эрхийн хамгааллын асуудалд тодорхой хүчин чармайлт гаргадаг бол эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухайд сурч боловсрох, соёл, эрүүл мэндийн үйлчилгээ авах эрхийг нь өргөжүүлэх замаар иргэний амьжиргааны чанарыг дээшлүүлэхэд голлон үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн хүний хөдөлмөрлөх эрхийг хөхиүлэн дэмжих бодлогынхоо хүрээнд Монгол Улсын Засгийн газар хөгжлийн бэрхшээлтэй болон хөдөлмөрийн хөлсний дундаж хэмжээнээс доогуур орлоготой иргэдэд эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх, тэдгээр иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж, бололцоог нэмэгдүүлэхэд анхаарч байна. Түүнчлэн 2008 онд эрх зүйн туслалцааны төвийг бүх аймаг, дүүрэгт байгуулсан бөгөөд төвийн зорилго нь төлбөрийн чадваргүй, эмзэг бүлгийн иргэд мөнгө, санхүү, нийгмийн гарал үүсэл, байдлаасаа шалтгаалан хууль зүйн туслалцаа авч чадахгүйн улмаас эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд оршиж байна.

9. Монгол Улсын Засгийн газар хууль тогтоомж боловсруулах, бодлого тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхэд алагчлахгүй байх бодлого барих замаар үндэсний цөөнхийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих боломжийг үргэлж эрэлхийлдэг. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуульд үндэсний цөөнхийн эх хэлээрээ суралцах, харилцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах эрхийг хөндөхгүй байх зохицуулалтыг тусгаснаараа үндэсний цөөнхийн эрхийг баталгаажуулж буй хэрэг юм.

10. Иргэдийнхээ улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах зорилгоор хүний эрхийн гэрээний байгууллагуудаас гаргасан буюу тогтоосон олон улсын хэм хэмжээ, стандартыг хэрэгжүүлэхэд ач холбогдол өгч байна. Түүнчлэн, иргэдийн эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх үүднээс эрх зүйн албан бус сургалтыг эрх зүйн олон чиглэлээр тогтмол явуулж байна.